



БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баян-Өлгий аймгийн Зоонозын өвчин судлалын төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БӨА-2023/184/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Өлгий хот
2023 он

Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын
дарга, тэргүүлэх аудитор: М.Хуанган
Утас: 70422954 Цахим хаяг: khuanganm@audit.gov.mn
Аудитын менежер: Х.Женисбек
Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn
Ахлах аудитор: Х.Манаргүл
Утас: 95429524 Цахим хаяг: manargulx@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	4
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	6
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	Error! Bookmark not defined.
4. АУДИТЫН ТАЙЛАН	Error! Bookmark not defined.
4.1 Ерөнхий зүйл.....	Error! Bookmark not defined.
4.2 Материаллаг байдал.....	Error! Bookmark not defined.
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	Error! Bookmark not defined.
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	Error! Bookmark not defined.
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	Error! Bookmark not defined.
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	Error! Bookmark not defined.
4.5.1 Завсрын аудитын талаар.....	Error! Bookmark not defined.
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	Error! Bookmark not defined.
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	Error! Bookmark not defined.
5.1 Төлбөрийн акт	Error! Bookmark not defined.
5.2 Албан шаардлага	Error! Bookmark not defined.
5.3 Зөвлөмж.....	Error! Bookmark not defined.
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	Error! Bookmark not defined.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

 БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР 83129 Өлгий, Баян-Өлгий аймаг, Утас/Факс: (976) 7042-2954 E-mail: bayanulgi@audit.gov.mn	ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН ТӨВИЙН ДАРГА Ч.ҮРЖИХ ТАНАА
<u>2023 о.д. 20</u> № <u>108</u> танай _____ -ны № _____ -т	
Өөрчлөлтгүй дүгнэлт	
<p>Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баян-Өлгий аймгийн Зоонозын өвчин судлалын төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.</p> <p>Баян-Өлгий Аймгийн Зоонозын өвчин судлалын төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.</p>	
Дүгнэлтийн үндэслэл	
<p>Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.</p>	
Асуудлыг онцолсон хэсэг	
<p>Тайлант онд нийтдээ 165.9 сая төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгсэлийг үнэ төлбөргүй хүлээн авч данс бүртгэлд тусгасан байна.</p>	
Аудитын гол асуудал	
<p>Материаллаг буруу эрсдэлийн үнэлгээ өндөр анхаарал татах асуудал гараагүй болно.</p>	
Бусад асуудлын хэсэг	
<p>Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.</p>	
Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага	
<p>Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.</p> <p>Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.</p>	

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  М.ХУАНГАН



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>29,816,143.00</u>	<u>205,785,149.15</u>
33	АВЛАГА	-	602,259.00
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	-	602,259.00
35	БАРАА МАТЕРИАЛ	29,816,143.00	205,182,890.15
351	Түүхий эд материал	883,595.00	949,795.00
35130	Эм боох материал	883,595.00	949,795.00
354	Хангамжийн материал	28,932,548.00	204,233,095.15
35410	Бичиг хэргийн материал	418,500.00	418,500.00
35420	Аж ахуйн материал	28,109,370.00	203,624,495.15
35430	Сэлбэг хэрэгсэл	182,100.00	182,100.00
35470	Бусад хангамжийн материал	8,000.00	8,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>828,399,396.77</u>	<u>790,066,007.13</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	828,399,396.77	790,066,007.13
392	Биет хөрөнгө	762,649,396.77	724,316,007.13
39201	Барилга, байгууламж, орон сууц	756,547,040.67	756,547,040.67
39202	Хуримтлагдсан элэгдэл	(46,867,880.36)	(72,921,686.48)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	64,967,000.00	64,967,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(56,057,000.00)	(61,997,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	145,929,395.68	120,616,874.08
39206	Хуримтлагдсан элэгдэл	(118,873,895.96)	(96,017,026.16)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	16,445,508.00	15,940,508.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(9,865,771.26)	(11,707,202.98)
39214	Бусад үндсэн хөрөнгө	14,350,000.00	13,500,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(3,925,000.00)	(4,612,500.00)
393	Биет бус хөрөнгө	65,750,000.00	65,750,000.00
39301	Програм хангамж	550,000.00	550,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(550,000.00)	(550,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	65,750,000.00	65,750,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>858,215,539.77</u>	<u>995,851,156.28</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>858,215,539.77</u>	<u>995,851,156.28</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	858,215,539.77	995,851,156.28
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	309,088,442.00	309,088,442.00
51101	Өмч: - төрийн	309,088,442.00	309,088,442.00
512	Хуримтлагдсан үр дүн	752,804.62	138,388,421.13
51210	Өмнөх үеийн үр дүн	31,465,267.44	752,804.62
51220	Тайлант үеийн үр дүн	(30,712,462.82)	137,635,616.51
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	548,374,293.15	548,374,293.15
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>858,215,539.77</u>	<u>995,851,156.28</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	592,614,358.00	699,119,495.15
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	47,634,400.00	173,915,795.15
120	Нийтлэг татварын бус орлого	-	173,915,795.15
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	-	173,915,795.15
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого		173,915,795.15
122	Тусламжийн орлого	47,634,400.00	-
122001	Хандив тусламж /дотоод/	47,634,400.00	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	544,979,958.00	525,203,700.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	471,832,400.00	509,843,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	471,832,400.00	509,843,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	73,147,558.00	15,360,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	22,429,558.00	11,860,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	50,718,000.00	3,500,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	623,326,820.82	561,483,878.64
21	УРСГАЛ ЗАРДАЛ	623,326,820.82	561,483,878.64
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	583,676,350.82	560,981,652.64
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	375,670,432.00	400,016,986.00
210101	Үндсэн цалин	270,049,709.00	282,162,088.00
210102	Нэмэгдэл	58,062,961.00	65,330,619.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	16,903,000.00	17,907,000.00
210104	Урамшуулал	30,654,762.00	34,617,279.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	53,873,686.00	55,133,573.00
210201	Тэтгэврийн даатгал	53,873,686.00	34,912,605.20
210202	Тэтгэмжийн даатгал	-	4,190,727.27
210203	ҮОМШӨ-ний даатгал	-	7,188,029.03
210204	Ажилгүйдлийн даатгал	-	855,514.61
210205	Эрүүл мэндийн даатгал	-	7,986,696.89
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	8,742,422.00	8,581,578.00
210301	Гэрэл, цахилгаан	1,312,922.00	1,752,895.00
210302	Түлш, халаалт	7,429,500.00	6,828,683.00
2104	Хангамж, бараа материалын зардал	15,694,165.00	17,030,291.00
210401	Бичиг хэрэг	979,100.00	1,450,226.00
210402	Тээвэр, шатахуун	10,132,600.00	11,331,115.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,286,500.00	695,200.00
210404	Ном, хэвлэл	472,800.00	
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	822,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,823,165.00	2,731,350.00
2105	Нормативт зардал	16,452,235.00	11,001,354.00

Баян-Өлгий аймгийн Зоонозын өвчин судлалын төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	15,367,235.00	9,401,354.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,085,000.00	1,600,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	71,857,065.00	7,945,140.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	234,200.00	1,538,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	69,046,665.00	4,589,840.00
210604	Урсгал засвар	2,576,200.00	1,817,300.00
2107	Томиллолт, зочны зардал	7,256,000.00	10,483,741.00
210702	Дотоод албан томиллолт	7,256,000.00	10,483,741.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,392,000.00	3,800,100.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	300,000.00	
210803	Даатгалын үйлчилгээ	350,000.00	350,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	106,500.00	196,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	99,000.00	99,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	405,000.00	3,023,100.00
210807	Газрын төлбөр	131,500.00	131,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	32,738,345.82	46,988,889.64
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорөгдол	32,738,345.82	46,988,889.64
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	39,650,470.00	502,226.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	39,640,060.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	39,640,060.00	
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	10,410.00	502,226.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	10,410.00	502,226.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>(30,712,462.82)</u>	<u>137,635,616.51</u>
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>(30,712,462.82)</u>	<u>137,635,616.51</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>546,280,018.00</u>	<u>525,203,700.00</u>
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	546,280,018.00	525,203,700.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	471,832,400.00	509,843,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	471,832,400.00	509,843,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	74,447,618.00	15,360,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	22,429,558.00	11,860,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	52,018,060.00	3,500,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>538,506,818.00</u>	<u>524,479,300.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	538,506,818.00	524,479,300.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	498,856,348.00	523,374,815.00

Баян-Өлгий аймгийн Зоонозын өвчин судлалын төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	375,240,635.00	400,408,500.00
210101	Үндсэн цалин	238,868,490.00	269,103,633.00
210102	Нэмэгдэл	83,497,100.00	82,539,303.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	18,701,545.00	17,844,000.00
210104	Урамшуулал	34,173,500.00	30,921,564.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	54,682,910.00	51,708,000.00
210201	Тэтгэврийн даатгал	36,472,610.00	34,481,500.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,642,100.00	4,056,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,555,700.00	4,245,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	728,400.00	811,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	7,284,100.00	8,113,300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	8,327,000.00	8,367,000.00
210301	Гэрэл, цахилгаан	1,312,922.00	1,752,895.00
210302	Түлш, халаалт	7,014,078.00	6,614,105.00
2104	Хангамж, бараа материалын зардал	15,937,385.00	19,468,515.00
210401	Бичиг хэрэг	993,500.00	1,450,226.00
210402	Тээвэр, шатахуун	9,566,420.00	11,331,115.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,286,500.00	695,200.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,249,800.00	976,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,841,165.00	5,015,574.00
2105	Нормативт зардал	17,906,568.00	12,790,600.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	11,482,568.00	8,941,600.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	6,424,000.00	3,849,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	17,798,850.00	8,943,300.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,341,000.00	2,208,600.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	13,881,650.00	4,917,400.00
210604	Урсгал засвар	2,576,200.00	1,817,300.00
2107	Томилолт, зочны зардал	7,256,000.00	13,517,800.00
210702	Дотоод албан томилолт	7,256,000.00	13,517,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,707,000.00	4,171,100.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	300,000.00	
210803	Даатгалын үйлчилгээ	350,000.00	350,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	106,500.00	196,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	99,000.00	99,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	720,000.00	3,394,100.00
210807	Газрын төлбөр	131,500.00	131,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	4,000,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		4,000,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	39,650,470.00	1,104,485.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	39,640,060.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	39,640,060.00	
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	10,410.00	1,104,485.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	10,410.00	1,104,485.00

3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>7,773,200.00</u>	<u>724,400.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	7,773,200.00	724,400.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	7,773,200.00	724,400.00
2200	Дотоод эх үүсвэрээр	7,773,200.00	724,400.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	7,773,200.00	724,400.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(7,773,200.00)</u>	<u>(724,400.00)</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	309,088,442.00	548,374,293.15	752,804.62	858,215,539.77
D01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	309,088,442.00	548,374,293.15	752,804.62	858,215,539.77
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	309,088,442.00	548,374,293.15	752,804.62	858,215,539.77
D08	Тайлант үеийн үр дүн			137,635,616.51	137,635,616.51
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	309,088,442.00	548,374,293.15	138,388,421.13	995,851,156.28

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	509,843,700.00	509,341,474.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	509,843,700.00	509,341,474.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	509,341,500.00	509,341,474.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	400,408,500.00	400,408,500.00
210101	Үндсэн цалин	255,162,400.00	269,103,633.00
210102	Нэмэгдэл	88,260,800.00	82,539,303.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	18,711,000.00	17,844,000.00
210104	Урамшуулал	38,274,300.00	30,921,564.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	51,708,000.00	51,708,000.00
210201	Тэтгэврийн даатгал	34,481,500.00	34,481,500.00

Баян-Өлгий аймгийн Зоонозын өвчин судлалын төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210202	Тэтгэмжийн даатгал	4,056,600.00	4,056,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,245,300.00	4,245,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	811,300.00	811,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	8,113,300.00	8,113,300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	8,367,000.00	8,367,000.00
210301	Гэрэл, цахилгаан	1,335,000.00	1,752,895.00
210302	Түлш, халаалт	7,032,000.00	6,614,105.00
2104	Хангамж, бараа материалын зардал	13,630,800.00	13,630,774.00
210401	Бичиг хэрэг	1,433,200.00	1,433,200.00
210402	Тээвэр, шатахуун	7,010,400.00	7,010,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	695,200.00	695,200.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	976,400.00	976,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,515,600.00	3,515,574.00
2105	Нормативт зардал	9,790,600.00	9,790,600.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	5,941,600.00	5,941,600.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,849,000.00	3,849,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,943,300.00	8,943,300.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,208,600.00	2,208,600.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	4,917,400.00	4,917,400.00
210604	Урсгал засвар	1,817,300.00	1,817,300.00
2107	Томилолт, зочны зардал	11,597,800.00	11,597,800.00
210702	Дотоод албан томилолт	11,597,800.00	11,597,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,895,500.00	4,895,500.00
210803	Даатгалын үйлчилгээ	350,000.00	350,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	196,500.00	196,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	99,000.00	99,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,118,500.00	4,118,500.00
210807	Газрын төлбөр	131,500.00	131,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	502,200.00	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	502,200.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	502,200.00	
13	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	509,843,700.00	509,341,474.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	509,843,700.00	509,341,474.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	509,843,700.00	509,341,474.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1
610001	Төсвийн байгууллага	1	1
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	27	27
620001	Удирдах ажилтан	1	1
620002	Гүйцэтгэх ажилтан	7	7
620003	Үйлчлэх ажилтан	19	19
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	27	27
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	20	20
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	7	7

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	58,777,691.00	14,757,741.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	58,777,691.00	14,757,741.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	58,777,691.00	14,757,741.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	23,423,195.00	-
210101	Үндсэн цалин	23,423,195.00	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,189,356.00	-
210201	Тэтгэврийн даатгал	3,189,356.00	
2104	Хангамж, бараа материалын зардал	3,555,550.00	5,837,741.00
210401	Бичиг хэрэг		17,026.00
210402	Тээвэр, шатахуун	3,555,550.00	4,320,715.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		1,500,000.00
2105	Нормативт зардал	11,262,200.00	3,000,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	10,320,700.00	3,000,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	941,500.00	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,407,890.00	-
210601	Багаж, техник, хэрэгсэл	386,400.00	
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	12,021,490.00	
2107	Томилолт, зочны зардал	1,229,500.00	1,920,000.00
210702	Дотоод албан томилолт	1,229,500.00	1,920,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,710,000.00	4,000,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,710,000.00	4,000,000.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,300,060.00	602,259.00
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	1,300,060.00	602,259.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	60,077,751.00	15,360,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	60,077,751.00	15,360,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6,748,450.00	11,257,741.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	28,592,051.00	3,500,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	24,737,250.00	
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар

Баян-Өлгий аймгийн Зоонозын өвчин судлалын нь аймгийн хэмжээнд шинэ ба сэргэн тархаж буй байгалийн голомтот, зоонозын халдварт өвчний чиглэлээр эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх, бусад мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллах чиг үүрэг бүхий эрүүл мэндийн байгууллага юм.

Зоонозын өвчин судлалын төвийн зорилго нь: Аймгийн хэмжээнд зоонозын өвчний хяналт тандалтыг оновчтой төлөвлөх, зоонозын шинэ ба сэргэн тархаж буй халдварт өвчнүүд болон тарваган тахал өвчнөөс эрт сэрэмжлүүлэх, хариу арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулах, мэдээлэл, сургалт сурталчилгааг эрчимжүүлэн хүн амд зоонозын өвчнөөс сэргийлэх талаар эрүүл мэндийн боловсрол олгох замаар халдварын эрсдэлийг багасган хүн амын өвчлөл эндэгдлийг бууруулах

Дээрх зорилгынхоо хүрээнд дараах зорилтыг тавьж ажилласан байна.Үүнд:

1. Аймгийн хэмжээнд шинэ ба сэргэн тархаж буй зоонозын халдварт өвчний байгалийн голомтын шинжилгээг оновчтой явуулснаар голомтыг илрүүлэх, хянах, орон нутгийн зэрэглэлд оруулж бүсчлэх
2. Шинэ ба сэргэн тархаж буй зоонозын болон байгалийн голомтот халдварт өвчний лабораторийн шинжилгээ, оношилгооны бэлэн байдлыг хангах
3. Шинэ ба сэргэн тархаж буй зоонозын болон байгалийн голомтот халдварт өвчний голомт хяналтын шинжилгээнд голомтын төлөвийг лабораторийн шинжилгээгээр батлах
4. Шинэ ба сэргэн тархаж буй зоонозын халдварт өвчнөөс эрт сэрэмжлүүлэх хариу арга хэмжээний сургалт зохион байгуулах
5. Байгууллагын албан хаагчдыг мэргэшүүлэх сургалтад хамруулах
6. Ажлын байран дээрх сургалтыг зохион байгуулж ажилтан албан хаагчдын мэдлэг ур чадварыг дээшлүүлэх
7. Байгууллагын удирдлага хөгжлийг сайжруулах
8. Дархлаажуулалтын үйл ажиллагааг зохион байгуулах дэглэмийн мөрдөлт хяналтыг сайжруулах

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар

Аймгийн Зоонозын өвчин судлалын төв нь үйл ажиллагаандаа Эрүүл мэндийн тухай хууль, Төсвийн тухай, Төрийн албаны тухай, Хөдөлмөрийн тухай, Шилэн дансны тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөж ажилласан байна.

Тус байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Зоонозын өвчин судлалын төвийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Зоонозын өвчин судлалын төв нь Эрүүл мэндийн сайдын 2010 оны “Эрүүл мэндийн яамны салбарын НББ-ийн бодлогын баримт бичиг батлах тухай” 138 дугаар тушаалаар баталсан НББ-ын бодлогын баримт бичгийг мөрдсөн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Зоонозын өвчин судлалын төвийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 137.0 сая төгрөгөөр буюу 15.9 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/мянган төгрөгөөр/	
		Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	-	602.3	602.3
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	29,816.1	205,182.9	175,366.7
Үндсэн хөрөнгө	828,399.4	790,066.0	(38,333.4)
Нийт хөрөнгө	858,215.5	995,851.2	137,635.6
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	858,215.5	995,851.2	137,635.6
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	858,215.5	995,851.2	137,635.6

Дээрх хүснэгтээс харахад дараах данснуудад нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна.

Мөнгөн хөрөнгийн данс оны эхэн ба эцэст үлдэгдэлгүй байна. Авлагын данс үндсэн болон нэмэлт дансны жилийн эцэст татан төвлөрүүлсэн бүгд 0.6 сая төгрөгөөр авлагатай гарсан байна:

Бараа материалын дансны үлдэгдэл 205.2 сая төгрөг болж 175.4 сая төгрөгөөр өссөн. Тайлант онд төсвийн хөрөнгөөр 47.6 сая төгрөгийн бараа материалыг худалдан, аймгийн ЭМГ-аас 165.9 сая төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгсэл үнэ төлбөргүй бүгд 213.5 сая төгрөгийн бараа материалыг хүлээн авч 38.3 сая төгрөгийг үйл ажиллагаанд зарцуулсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 790.1 сая төгрөг болж 38.3 сая төгрөгөөр буурсан нь 0.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг төсвийн хөрөнгөөр худалдан авч, ЭМЯ-наас 7.9 сая төгрөгийн машин тоног төхөөрөмжийг үнэ төлбөргүй хүлээн авсан ба 35.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг Аймгийн ИТХ-лын хуралдааны 2022 оны 104 дүгээр тогтоолыг үндэслэн акталж данс бүртгэлээс хассантай холбоотой байна.

Тайлант онд 137.6 сая төгрөгийн үр дүнтэй ажилласантай холбоотой Засгийн газрын хувь оролцоо данс 137.6 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр 730.0 сая, нийт зарлагыг 730.0 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас ажилагсадтай холбоотой зардал 214.4 сая, хангамж бараа материалын зардлыг 0.7 сая, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 0.9 сая, норматив зардал 3.4 сая, эд хогшил урсгал зардал 1.1 сая, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж 0.2 сая төгрөгөөр нийтдээ 220.2 сая төгрөгөөр бууруулан 509.8 сая төгрөгөөр баталсан байна.

Зоонозын өвчин судлалын төвийн 2022 оны анх батлагдсан төсөв 468.2 сая төгрөг ба тодотгосон төсөв 509.8 сая төгрөг байна. Тодотгосон төсөв нь анх баталсанаас 41.6 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх нийгмийн эрүүл мэнд гэсэн 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 509.8 сая төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр тусгасан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 509.8 сая төгрөгийн санхүүжилт олгосон ба гүйцэтгэл 100.0 хувьтай байна. Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 509.3 сая төгрөг буюу 99.9 хувьтай байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 509.3 сая төгрөг буюу 99.9 хувьтай байгаа нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулалд батлагдсан 0,5 сая төгрөгийг хэмнэж хэмнэгдсэн төсвийг төсөвт төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Үндсэн үйл ажиллагааны зардал	509,341.5	509,341.5	-	100%
2	Ажил олгогчоос олгох тэтгэмж,	502.2		(502.2)	0%
	Дүн	509,843.7	509,341.5	(502.2)	100%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд аймгийн Засаг даргын 2022 оны А/284,А/550 захирамжуудаартарваган тахал өвчинөөс урьдчилан сэргийлэх аянд бүгд 11.8 сая, ЗӨСҮТөвөөс сургалт сурталчилгаанд 3.5 сая, бүгд 15.3 тсая өгрөгийг төвийн нэмэлт санхүүжилтээр авч зориулалтын дагуу зарцуулагдсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Зоонозын өвчин судлалын төв нь 2022 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Баян-Өлгий аймгийн Зоонозын өвчин судлалын төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах хууль тогтоомжийн хэрэгжилт, бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Х.Манаргүл гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар тус тус хэрэгжүүлсэн.

Аймгийн Зоонозын өвчин судлалын төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 15 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 12465.5 сая төгрөгөөс 2.0 хувиар буюу 12.5 сая төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзэв.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотой төсвийг хэмнэх талаар 29 арга хэмжээний хэрэгжилтийг шалгаж үзэхэд алдаа зөрчил илрээгүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т /шилэн дансны мэдээлэл/ тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аймгийн Зоонозын өвчин судлалын төв нь 2022 онд нийт 464.1 сая төгрөгийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас шилэн дансанд мэдээлсэн байдлын хэрэгжилтийн хувь 100% байна. Төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг байршуулсан байна.

Тайлант онд Засаг даргын дэргэдэх Санхүүгийн, хяналт дотоод аудитын алба, ЭМГ-ын хяналт шинжилгээ үнэлгээний хэлтсийн дотоод аудитор шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн төсвийн зарцуулалт нь Төсвийн тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Аймгийн Зоонозын өвчин судлалын төвийн 2022 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд хийсэн завсрын аудитаар алдаа зөрчил илрээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төлбөрийн акт тогтоогдоогүй, албан шаардлага, зөвлөмж өгөгдөөгүй байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарал хандуулах зүйл гараагүй. Цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалж тус байгууллагын үндсэн болон нэмэлт дансны санхүүжилтийн зарцуулалтыг бүрэн шалгах боломжгүй, зөвхөн санхүүгийн тайлан гаргалтыг шалгаж баталгаажууллаа.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 121.7 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс аудитын явцад залруулга хийгдээгүй, 121.7 сая төгрөгийн алдаа зөрчлийг дахин давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өгөв.

5.1 Төлбөрийн акт

Тогтоосон төлбөрийн акт байхгүй

5.2 Албан шаардлага

Албан шаардлага байхгүй

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгийн үнэлгээтэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн цаашид ашиглах боломжтой 76 нэр төрлийн 121.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн үнийг шинэчлэн тогтоогоогүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж:

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 3.2-т “илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох”, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журмын 7 дугаар зүйлийн 7.1-д “Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох” гэсэн заалтыг мөрдөж, ээлэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн цаашид ашиглах боломжтой үндсэн хөрөнгийн үнийг шинэчлэн тогтоох.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		

/мянган төгрөгөөр/

Баян-Өлгий аймгийн Зоонозын өвчин судлалын төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Дүн													
-----	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн хөрөнгийн үнийг зохих журмын дагуу шинэчлэн тогтоогоогүй	1	121744.3					1	121744.3					
Дүн	1	121744.3					1	121744.3					

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								